



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 10 өдөр

Дугаар A/16

Мандалговь

Гамшиг, онцгой байдлын үед ажиллах  
хүүхэд хамгааллын мэргэжлийн  
анги байгуулах тухай

Хүүхдийн эрхийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.4 дэх заалт, Хүүхэд хамгааллын тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.2.7 дахь заалт, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.8 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Монгол улсын Засгийн газрын 2019 оны 05 дугаар сарын 22-ны өдрийн 201 дүгээр тогтоолоор батлагдсан "Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусlamж, дэмжлэг үзүүлэх журам"-ын 2.9.3 дахь заалт, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын 2020 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн A/24 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Онцгой нөхцөл байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэд тусlamж дэмжлэг үзүүлэх зорилгоор "Хүүхэд хамгааллын мэргэжлийн анги"-ийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.
2. Хүүхэд хамгааллын мэргэжлийн ангийн бүрэлдэхүүнийг онцгой байдлын үед хүүхдийн эрхийг хамгаалах, тусlamж дэмжлэг үзүүлэх журмын хэрэгжилтийг хангаж ажиллахыг мэргэжлийн ангийн ахлагч /Б.Цэцэг/, гишүүдэд үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргаа, хүний нөөц, хяналт шинжилгээ, үнэлгээ хариуцсан ахлах мэргэжилтэнд даалгасугай.

ДАРГА

Ц.ГАНЗОРИГ



481190021